

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР
ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР 2020 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРАЛД
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН
/2020.12.11-2020.03.31/

2020 оны 04 дүгээр сарын 01

Улаанбаатар хот

Нэг.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр

Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгжүүдээс авч нэгтгэн Төлөвлөгөөнд тусгагдсан 21 арга хэмжээнээс 2 арга хэмжээ 70, 19 арга хэмжээ 100 нийт 97,1 хувьтай дүгнэгдсэн бөгөөд нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөнд нэгжүүдээс санал авч нэгтгэн, хяналт-шинжилгээ хийлгэж, 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж гишүүдээс өгсөн саналыг тусган 37 арга хэмжээ төлөвлөн тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

Нэмэгдэл олгосон талаар:

№	Нэмэгдлийн төрөл	Албан хаагчийн тоо	Хэлбэр /хувь/
1	Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл	136	10-25
2	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	50	5-25

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5-д “Төрийн албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай” гэж заасны дагуу тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын хүрээнд төрийн үйлчилгээний 88 албан хаагчийн төрийн албанд ажилласан жилийг тогтоож, хугацаа хүрсэн 39 албан хаагчид байгууллагын даргын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар, хугацаа хүрсэн 11 төрийн захиргааны албан хаагчид 02 дугаар сарын 14-ний өдрийн Б/33 дугаар тушаалаар 5-25 хувийн нэмэгдлийг олгосон.

“Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолыг үндэслэн төвийн 95, орон нутаг дахь газрын 156 албан хаагчийн албан тушаалын цалинг шинэчлэн тогтоож байгууллагын даргын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар баталсан.

Албан хаагчдын авсан чөлөө:

№	Чөлөө	Хэлбэр	Албан хаагчийн тоо
1	Хүүхэд асрах чөлөө	тушаал	4
2	Сургалтад хамрагдах болон эрүүл мэндийн шалтгаанаар	тушаал	8 /9-60 хоног/
3	Төвийн албан хаагч	чөлөөний хуудас	27 /1-5 хоног/

	эмнэлгийн магадалгаа	3
	эмнэлгийн хуудас	6
Нийт		48

Тусламж олгосон талаар:

№	Тусламжийн төрөл	Албан хаагчийн тоо	Хэлбэр /төгрөг/
1	Ердийн галлагаатай орон сууцад амьдардаг албан хаагчдад түлшний хөнгөлөлт /нөхөн төлбөр/	19	2.280.000
2	Ар гэрийн гачигдал	5	3.160.000
3	Гэр бүлд нь шинээр хүүхэд төрсөн	6	600.000
Нийт			4.320.000

Урамшуулал олгосон талаар:

№	Урамшууллын төрөл	Албан хаагчийн тоо	Хэлбэр /төгрөг/
1	Ээлжийн амралт биеэр эдэлж чадаагүй	2	1.5 албан тушаалын цалин
2	Гэрээгээр заасан үүргээ сайн биелүүлсэн	3	1.645.299
3	2019 оны 1 дүгээр улирлын ажлын гүйцэтгэлээр хангалттай үнэлгээ авсан	70	19.410.300
4	2019 оны 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэлээр хангалттай үнэлгээ авсан	73	20.348.253
5	2019 оны 3 дугаар улирлын ажлын гүйцэтгэлээр хангалттай үнэлгээ авсан	76	21.096.396
6	Хилийн боомтод ажилласан хугацааны урамшуулал	1	21.354.672
7	Идэвх санаачилгатай ажилласан	15	7.895.184
Нийт		240 /давхардсан/	91.750.104

Шагнал олгосон талаар:

№	Шагналын төрөл	Албан хаагчийн тоо	Бусад байгууллагын ажилтан
1	Байгууллагын шагнал	45	1
2	Төрийн дээд одон медаль	5	-
3	Салбарын шагнал	6	-
4	Бусад байгууллагын шагнал	8	-
Нийт		64	1

Монгол Улсын уламжлалт баяр Цагаан сарын баярыг тохиолдуулан 2019 оны ажлын үр дүнгээр бусдыгаа тэргүүлж ажилласан төрийн дээд одон медальд нэр дэвшүүлсэн 13 албан хаагчийн материалыг бэлтгэж Даргын дэргэдэх зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцүүлж төрийн дээд одон медалиар шагнуулахаар 10 албан хаагчийн холбогдох материалыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/158 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2020 оны ээлжийн амралт эдлэх хугацааны саналыг төвийн газар, хэлтсээс авч нэгтгэн 101 албан хаагчийн улсад ажилласан жилийг шинэчлэн тогтоож төвийн газрын 94, орон нутгийн нэгжийн 7 даргын ээлжийн амралтын хуваарийг байгууллагын даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Б/08 дугаар тушаалаар батлуулсан.

Хоёр.Албан хаагчдын томилгоо, сахилга хариуцлагын талаар

Албан тушаалын томилгоо:

№	Албан тушаал	Албан хаагчийн тоо
1	Төрийн захиргаа	3
2	Төрийн үйлчилгээ	5
3	Хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн чөлөөний хугацаанд түр	2
4	Түр	2
5	Хүүхэд асрах чөлөөнөөс эгүүлэн	1
6	Нэгж хооронд шилжин	9
7	Дэвшүүлэн томилогдсон	4
8	Албан тушаал бууруулан томилсон	-
9	Нэгж хооронд сэлгэн ажилласан	-
10	Өөр байгууллагад сэлгэн ажилласан	-
Нийт		26

Албан тушаалаас чөлөөлөгдсөн:

№	Албан тушаал	Албан хаагчийн тоо	
		Төрийн захиргаа	Төрийн үйлчилгээ
1	Тэтгэвэрт гарах нас хүрсэн	1	-
2	Өөрийн хүсэлтээр	7	3
3	Өөр байгууллагад шилжсэн	1	-
4	Дутагдлаар халагдсан	1	1
5	Урт хугацааны сургалтад хамрагдах	-	-
Нийт		14	

Сахилга, хариуцлага:

№	Сахилгын шийтгэлийн төрөл	Албан хаагчийн тоо	
		Төрийн захиргаа	Төрийн үйлчилгээ
1	Сануулах	2	-
2	Албан тушаалын цалинг 3 сарын хугацаагаар 10 хувиар бууруулах	1	-
3	Ажлаас халах	1	2
Нийт		6	